



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2019.12.16 - 12.20

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. Энэхүү өсөлт нь АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрийн эхний үе шат амжилттай хэрэгжих болсонтой холбоотой юм.

S&P 500 индексийн сагсанд багтах Netflix компанийн олон улсын хэрэглэгчдийн тоо хүлээлтээс илүү өссөн хэмээх тайлан гарсантай холбоотой харилцаа холбооны салбар хамгийн өсөлттэй байлаа. Мөн, ус, дулаан, цахилгааны салбарт болон үл хөдлөх хөрөнгийн салбарт үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын хувьцааны ханш өсөлттэй байлаа. Харин, FedEx компанийн энэ улирлын ашигт ажиллагааны үзүүлэлтүүд сул байснаас үүдэн үйлдвэрлэлийн салбар уналттай байлаа.

Эдийн засгийн үзүүлэлтүүд болон, худалдааны хэлэлцээртэй холбоотойгоор 10 жилийн хугацаатай засгийн газрын үнэт цаасны өгөөж сүүлийн 1 сарын дээд төвшинд хүрлээ. Хөрөнгө оруулалтын зэрэглэлтэй компанийн бондын арилжаа сул байсан ч засгийн газрын үнэт цаас болон компанийн бондын өгөөжийн зөрүү буурсан байна.

Европ: Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны хэлэлцээрт ахиц гарсантай болон Их Британийн Ерөнхий сайд ноён Борис Жонсон болон түүний Консерватив нам сонгуульд ялалт байгуулсантай холбоотой өсөлттэй байлаа.

Их Британийн Ерөнхий сайд ноён Борис Жонсон хэлэлцээргүй Brexit болох айдсыг нэмснээс үүдэн фунтийн ханш суларлаа. Тэрээр Brexit-ийн гэрээнд заасан, Европын холбоотой худалдааны гэрээг эцэслэх шилжилтийн үе болох 2020 оны эцсийг сунгах боломжгүй болгох өөрчлөлт гэрээнд оруулахаа мэдэгдсэн байна.

Хэрэв хэлэлцээрт хүрч чадахгүй бол Европын холбоо болон Их Британи улсын эдийн засгийн харилцаа нь дэлхийн худалдааны байгууллагын зохицуулалтуудаар зохицуулагдаж эхлэх юм.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд хөдөлгөөн багатайгаар хаагдлаа.

Япон улсын төв банк мөнгөний бодлогын богино хугацааны зорилтот хүүг -0.1%, урт хугацааны зорилтот хүүг 0% хэвээр байлгах шийдвэр гаргасан байна. Мөн, Пүрэв гарагийн ТУЗ-ийн хурлаар Япон улсын төв банк хөрөнгө худалдан авалтын төвшинд өөрчлөлт оруулахгүй гэсэн шийдвэр гаргасан байна.

БНХАУ: АНУ болон БНХАУ-ын хоорондын худалдааны эхний шатны хэлэлцээртэй холбоотойгоор БНХАУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд дахин өсөлттэй байлаа.

Хэдийгээр энэхүү хэлэлцээр нь хөрөнгө оруулагчдын богино хугацааны айдсыг намдаасан ч БНХАУ болон АНУ-ын хоорондын үйлдвэрлэлийн бодлого, оюуны өмч, технологийн шилжүүлэг зэрэг үндсэн асуудлуудад ямар нэг шийдэл авч ирээгүй байна.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	18,891.53	-0.84% ▼
Dow Jones	АНУ	28,455.09	1.14% ▲
S&P 500	АНУ	3,221.22	1.65% ▲
Nasdaq	АНУ	8,924.96	2.18% ▲
S&P/TSX	Канад	17,118.44	0.68% ▲
FTSE 100	Их Британи	7,582.48	3.11% ▲
S&P/ASX 200	Австрали	6,816.30	1.14% ▲
Nikkei 225	Япон	23,816.63	-0.86% ▼
Hang Seng	Хонг Конг	27,871.35	0.66% ▲

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	113.82
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	103.48
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	102.51
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	109.30
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	102.93
DBM' 2023	USD	7.250%	106.09
TDBM' 2020	USD	9.375%	102.04
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	97.36

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	1.780	0.04 ▲
Libor 3M	1.935	0.04 ▲
Libor 6M	1.921	0.02 ▲
Libor 1YR	2.000	0.04 ▲
US 2YR Bond	1.627	0.01 ▲
US 3YR Bond	1.657	0.02 ▲
US 5YR Bond	1.727	0.06 ▲
US 10YR Bond	1.908	0.07 ▲

Валютын ханш /төг/

Валют	2019.12.20	Өөрчлөлт
USD	2,731.72	0.21% ▲
CNY	389.74	-0.14% ▼
EUR	3,037.13	-0.34% ▼
RUB	43.79	0.46% ▲
KRW	2.35	0.86% ▲
JPY	24.98	0.44% ▲
CAD	2,078.70	0.32% ▲

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /spot/	USD/t oz.	1,481.64	0.36% ▲
Мөнгө /spot/	USD/t oz.	17.20	1.57% ▲
Зэс	USD/lb.	280.60	0.90% ▲
Нүүрс	USD/MT	67.58	-1.10% ▼
WTI газрын тос	USD/bbl.	60.44	0.62% ▲
Brent газрын тос	USD/bbl.	66.14	1.41% ▲

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2019. X	7.60%
Бодлогын хүү	2019. X	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2019. X	11.06%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2019. X	11.48%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2019. X	4.82%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2019. X	16.90%
Зээлийн дундаж хүү /валют/	2019. X	10.61%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 61 компанийн 1,416.0 сая төгрөгийн 17,818,167 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Хасу-Мандал” /HSR/ компанийн хувьцаа 15.39%-аар буюу хамгийн ихээр өсөж 7,460.0 төгрөгт хүрч хаагдсан бол “Эрдэнэт зандан” /IND/ компанийн хувьцаа 13.97%-аар буурч 1,700.0 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


12-р сарын 20-ний өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,604.7 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 18,891.53 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.84%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2019 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	1,416.0
Зах зээлийн үнэлгээ	2,604,651.7

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	18,891.53	-0.84% ▼
MSE I индекс	9,104.45	-0.78% ▼
MSE II индекс	7,806.74	0.63% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Мандал даатгал	12,271,338	624,895,295
Ард кредит ББСБ	3,809,271	295,442,312
Ард санхүүгийн нэгдэл	82,841	155,080,056
Хөвсгөл алтан дуулга	141,212	98,846,930
АПУ	89,215	53,810,684

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Хасу-Мандал	7,460.00	15.39% ▲
Тээвэр дархан	8,625.00	15.00% ▲
Дархан гурил тэжээл	3,209.00	14.98% ▲
Тав	15,500.00	14.81% ▲
Тахь-Ко	11,400.00	14.00% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Эрдэнэт зандан	1,700.00	-13.97% ▼
Хэрлэн хивс	45.00	-10.00% ▼
Нако түлш	50.00	-9.09% ▼
Мандал даатгал	48.31	-7.10% ▼
Улаанбаатар хивс	16,050.00	-5.59% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Ард капитал групп	772,370,841
Ард секюритиз	698,810,457
Голомт капитал	661,816,902
Бумбат-Алтай	296,786,179
Ти ди би капитал	107,432,073

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	608.29	647,331
Таван толгой	6,670.00	351,277
МИК Холдинг	14,000.00	289,930
Говь	255.45	199,930
Инвескор ББСБ	2,172.00	155,793

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
---	-----------------	--------------------	-----------------	------------	------------	---------	-----

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	2018 оны цэвэр ашиг /сая төг/	Нийт хуваарилах ногдол ашиг /сая төг/	Ногдол ашиг төлөлтийн харьцаа	Нэгж хувьцааны ногдол ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	HRM	Гермес центр ХК	783.4	298.5	38.1%	3.8	2019.01.25	2019.02.18	2019.03.18-нд олгов
2	LEND	ЛэндМН ББСБ	2,560.3	800.0	31.2%	1.0	2019.01.30	2019.02.22	2019.03.28-нд олгов
3	MBW	Монгол Базальт ХК	217.2	56.4	26.0%	1.0	2019.02.01	2019.03.25	2019.06.14-нд олгов
4	BTG	Баянтээг ХК	1,771.4	1,000.0	56.5%	3,958.7	2019.02.11	2019.03.04	2019.06.01-с
5	SUL	Жуулчин дюти фрий ХК	1,384.5	653.6	47.2%	10,000.0	2019.02.12	2019.04.10	2019.05.31-с
6	GOV	Говь ХК	17,764.2	5,304.8	29.9%	6.8	2019.02.13	2019.03.28	2019.04.25-с
7	ADU	Хөвсгөл алтан дуулга ХК	399.2	1,888.1	473.0%	120.0	2019.02.13	2019.04.01	2019.05.01-с
8	TCK	Талх чихэр ХК	1,975.9	204.7	10.4%	200.0	2019.02.14	2019.04.03	2019.07.01-с
9	MMX	Мах импекс ХК	778.6	456.1	58.6%	120.0	2019.02.14	2019.04.03	2019.10.01-с
10	BUK	УБ-БҮК ХК	566.4	131.5	23.2%	1.0	2019.02.14	2019.04.05	2019.05.01-с
11	ТАН	Тахь-ко ХК	799.1	128.5	16.1%	108.0	2019.02.15	2019.04.05	2019.04.24-нд олгов
12	BNG	Баянгол зочид буудал ХК	3,433.1	150.2	4.4%	355.0	2019.02.16	2019.04.05	2019.09.01-с
13	MNP	Монгол шуудан ХК	1,560.3	468.1	30.0%	4.7	2019.02.18	2019.04.05	2019.05.01-с
14	HRD	Хүрд ХК	751.1	74.4	9.9%	550.0	2019.02.18	2019.03.04	2019.06.01-ний дотор
15	MNDL	Мандал даатгал ХК	3,868.3	624.3	16.1%	100.0	2019.02.18	2019.04.10	2019.05.27-нд олгов
16	GTL	Гутал ХК	2,225.8	1,257.7	56.5%	777.0	2019.02.18	2019.03.13	2019.05.06-с
17	TEX	Техник импорт ХК	2,702.0	723.4	26.8%	500.0	2019.02.18	2019.03.11	2019.04.11-с
18	APU	АПУ ХК	57,851.7	48,952.4	84.6%	46.0	2019.02.19	2019.04.04	2019.05.20-нд олгов
19	AIC	Ард даатгал ХК	1,263.4	631.8	50.0%	25.3	2019.02.19	2019.03.15	2019.06.17-нд олгов
20	GHC	Ган хийц ХК	20.3	12.1	59.7%	50.0	2019.02.19	2019.03.22	2019.10.21-нд олгов
21	HUV	Хөвсгөл геологи ХК	107.4	14.4	13.4%	100.0	2019.02.19	2019.04.03	2019.04.29-с
22	HNS	Хөвсгөл хүнс ХК	11.3	2.6	23.4%	10.0	2019.02.19	2019.04.03	2019.05.15-с
23	TAL	Талын гал ХК	255.9	34.7	13.6%	50.0	2019.02.25	2019.03.26	2019.07.19-нд олгов
24	BRC	Барилга корпораци ХК	1,311.0	40.1	3.1%	985.0	2019.02.26	2019.03.18	2019.03.18
25	UBH	Улаанбаатар хивс ХК	235.6	48.6	20.6%	120.0	2019.02.26	2019.03.18	2019.05.31-ний дотор
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ ХК	11.5	11.4	99.2%	1.1	2019.03.01	2019.03.21	2019.07.02-с
27	ADL	Адуунчулуун ХК	547.1	409.7	74.9%	130.0	2019.03.11	2019.04.03	2019.07.26-нд олгов
28	TEE	Тээвэр дархан ХК	22.3	81.7	365.5%	500.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
29	ERS	Монгол алт ХК	6.3	39.9	631.2%	150.0	2019.04.17	2019.03.27	2019.12.31-ний дотор
30	TTL	Таван толгой ХК	52,858.1	44,923.4	85.0%	853.0	2019.04.26	2019.04.01	2019.06.11-нд олгов
31	EER	Ариг гал ХК	449.3	109.4	24.3%	32.5	2019.04.26	2019.03.27	2019.09.30-ны дотор
32	HRM	Гермес центр ХК	481.3	447.7	93.0%	5.7	2019.08.15	2019.09.02	2019.09.18-нд олгов
33	SUU	Сүү ХК	5,706.4	1,143.4	20.0%	3.3	2019.09.09	2019.04.05	2019.10.24-нд олгов

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Атар өргөө” ХК-ийн тендер арилжаа явагдлаа

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.2 заалтад заасан “Компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа буюу холбогдох этгээдтэй хамтран худалдан авсан хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хуулийн 57.1-д заасан үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр компанийн хувьцааг худалдан авах санал гаргана” гэж заасныг удирдлага болгон “Таван Богд Инвест” ХХК нь МХБ-ийн үнэт цаасны 2-р ангилалд бүртгэлтэй “Атар-Өргөө” ХК-ийн 97,423 ширхэг энгийн хувьцааг нэг ширхгийг 60,200 төгрөгөөр худалдан авах санал гаргасан.

Хувьцааг худалдан авах тендер саналыг 2019 оны 11-р сарын 13-ны өдрөөс 2019 оны 12-р сарын 16-ны өдрийн 13:00 цаг хүртэл авсан бөгөөд “Атар-Өргөө” ХК-ийн 43 ширхэг буюу 2,592,900 төгрөгийн үнийн дүн бүхий тендер арилжаа хийгдсэн байна.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Хорго хайрхан” ХК-ийн арилжааг түр зогсоолоо

“Хорго Хайрхан” ХК-ийн 2019 оны 4-р сарын 25-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар “Монгол даатгал” ХХК-ийг өөртөө нэгтгэн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн асуудлыг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2019 оны 12-р сарын 16-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн компанийн нэгтгэлийг зөвшөөрч, оноосон нэр болон үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулсныг бүртгэсэн байна.

Уг шийдвэртэй холбогдуулан Улсын байцаагчийн 2019 оны 12-р сарын 16-ний өдрийн 88 тоот албан шаардлагаар өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулах үйл ажиллагаа “ҮЦТХТ” ХХК-д бүрэн хийгдэж дуусах хүртэлх хугацаанд тус үнэт цаасны арилжааг түр зогсоолоо.

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

“Хар хорум пропертийс” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын тов гарлаа

“Хар Хорум Пропертийс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 12-р сарын 14-ний өдрийн 03/2019 тоот тогтоолоор хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 01-р сарын 24-ний өдрийн 12:00 цагт хуралдуулахаар болсон байна.

Хувьцаа эзэмшигчдийн хуралдах хугацаа: 2020 оны 01-р сарын 24-ний өдрийн 12:00 цагт

Бүртгэх өдөр: 2020 оны 01-р сарын 05-ны өдөр

Хуралдах газар: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүргийн 1 дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 7/2, Денвер оффис, 401 тоот, Эрдэнэс Сольюшинс ХХК-ийн байр

Холбоо барих утас: 99922517

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

1. Компанийн үйл ажиллагааны тайлан;
2. “Эрдэнэс сольюшинс” ХХК-иас ирүүлсэн “Хар хорум пропертийс” ХК-ийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг энгийн хувьцааг тэнцүүлж, Компанийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төсөл, Нэгтгэх гэрээний төслийг хэлэлцэж батлах тухай;
3. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх талуудын 2019 оны 12-р сарын 31-ний байдлаар хөндлөнгийн аудит хийгдсэн санхүүгийн тайлан, хөрөнгийн үнэлгээний тайлан, хуулийн дүгнэлтийг хэлэлцэж, батлах тухай;
4. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан “Хар хорум пропертийс” ХК-ийн зарласан энгийн хувьцаанаас хаалттай хүрээнд 1 ширхэг нь 100 /нэг зуу/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1700'000'000 /нэг тэрбум долоон зуун сая/ ширхэг хүртэлх энгийн хувьцааг нэмж эргэлтэд гаргах тухай;
5. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хаалттай хүрээнд нэмж гаргах хувьцаанаас тэргүүн ээлжинд худалдан авах эрхийг эдлүүлэхгүй байх тухай;
6. “Хар хорум пропертийс” ХК-д “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэхтэй холбогдуулан хувьцаа эзэмшигч өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авах шаардах эрх үүссэн тухай;
7. “Хар хорум пропертийс” ХК-ийн үйл ажиллагааны чиглэлд нэмэлт оруулах тухай;
8. “Хар хорум пропертийс” ХК-ийн оршин байх хаягийг өөрчлөх тухай;
9. Хар хорум пропертийс ХК-ийн оноосон нэрийг нэгтгэж буй Эрдэнэс сольюшинс ХХК-ийн оноосон нэрээр солих тухай;
10. Хар хорум пропертийс ХК-ийн Дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг батлах тухай;
11. Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг шинээр томилох тухай.

Хурал зохион байгуулах коммисын бүрэлдэхүүн:
Хурал зохион байгуулах комиссын Дарга: Э.Сод-Эрдэнэ, Гишүүн: Э.Шагдарсүрэн

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Нүүрс 3.50 сая тонноор өсөж, алт 4.4 тонноор буурчээ

Уул уурхай, аж үйлдвэрийн салбараас улсын төсөвт оруулсан орлого 2.4 их наяд төгрөг болж, өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад 518.6 тэрбум төгрөг буюу 26.7 хувиар өссөн дүнтэй байна. Үүнээс:

- Нүүрс 1.1 их наяд төгрөг,
- Зэс 981.7 тэрбум төгрөг,
- Алт 112.5 тэрбум төгрөг,
- цайр 65.2 тэрбум төгрөг,
- төмөр 24.5 тэрбум төгрөг,
- жонш 29.9 тэрбум төгрөг,
- бусад орлого 69.5 тэрбум төгрөг.

Аж үйлдвэрийн салбарын гол нэр төрлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2019 оны эхний 11 сарын гүйцэтгэлээр:

- 47.87 сая.тн нүүрс,
- 1.17 сая.тн зэсийн баяжмал,
- 14.84 тн алт,
- 4.79 мян.тн молибдений баяжмал,
- 131.5 мян.тн хайлуур жоншны хүдэр,
- 42 мян.тн хайлуур жоншны баяжмал,
- 8.11 сая.тн төмрийн хүдэр,
- 3.06 сая.тн төмрийн хүдрийн баяжмал,
- 76.0 мян.тн цайрын баяжмал,
- 6.32 сая.баррель газрын тос тус тус үйлдвэрлэсэн байна.

Өнгөрсөн оны мөн үеийнхтэй харьцуулахад нүүрс 3.50 сая.тн буюу 7.9 хувь, төмрийн хүдэр 2.20 сая.тн буюу 37.4 хувь, хайлуур жоншны хүдэр 33.2 мян.тн буюу 33.8 хувь, газрын тос 539.8 мян.баррель буюу 9.3 хувиар тус тус өссөн байна.

Харин зэсийн баяжмал 33.2 мян.тн буюу 2.8 хувь, алт 4.4 тн буюу 22.9 хувь, молибдений баяжмал 266.5 тн буюу 5.3 хувь, төмрийн хүдрийн баяжмал 94.5 мян.тн буюу 3 хувь, хайлуур жоншны баяжмал 25.9 мян.тн буюу 38.1 хувь, цайрын баяжмал 1.8 мян.тн буюу 2.3 хувиар тус тус буурсан талаар УУХҮЯ-наас мэдээллээ.

Эх сурвалж: Montsame.mn

Хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэг жилээр зогсооно

Засгийн газрын ээлжит хуралдаан 2019 оны 12-р сарын 18-ны өдөр болж тусгай зөвшөөрөлтэй холбоотой асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ.

Хуралдаанаар ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг нэг жилийн хугацаанд олгохгүй байхаар шийдвэрлэлээ. Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшингээр ахлуулсан 40 хүнтэй Ажлын хэсэг 100 гаруй хоног ажиллан 2,889 тусгай зөвшөөрлийг нэг бүрчлэн шалгаж, нэгдсэн мэдээллийн сан бүрдүүлэх юм. Үүнийг иргэд, төрийн байгууллагууд ашиглах боломжтой. Цаашид хариуцлагатай уул уурхай эрхлэхтэй холбоотой хууль, дүрэм, журмыг мөрдүүлэх чиглэлээр ажиллана. Хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулаагүй гэсэн үндэслэлээр сүүлийн гурван жилд уул уурхайн 700 гаруй тусгай зөвшөөрлийг цуцлаад байна. Ингэснээр 3,500 орчим байсан тусгай зөвшөөрлийн тоо 2,889 болж буурчээ. Үүний 1,664 нь ашиглалтын, 1,225 нь хайгуулын тусгай зөвшөөрөл юм гэж Засгийн газрын Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтэс мэдээллээ.

Эх сурвалж: Montsame.mn

Газрын тосноос 210.2 тэрбумын орлого төвлөрүүлжээ

Улсын хэмжээнд энэ онд нийт 8.15 сая баррель буюу 1.1 сая тн газрын тос олборлон экспортод гаргаад байна.

Газрын тосны олборлолтоос улсын төсөвт 335.6 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх төлөвлөгөөтэй. Үүнээс энэ 12-р сарын 4-ний байдлаар улсын хэмжээнд 6.39 сая баррель буюу 867.1 мян.тн (78.47 хувь) газрын тос олборлож, 6.09 сая баррель буюу 827.7 мян.тн (74.79 хувь) газрын тос экспортолж 12-р сарын 15-ны байдлаар 210.2 тэрбум төгрөг (62.6 хувийн)-ийн орлого хуримтлуулаад байна.

Харин газрын тосны бүтээгдэхүүнээр 12-р сарын 10-ны байдлаар улсын хэмжээнд дунджаар ердийн хэрэглээний 33 хоногийн нөөцтэй байна. Үүнээс:

- А-80 автобензин 61 хоногийн нөөцтэй,
- Аи-92 автобензин 33 хоногийн нөөцтэй,
- Дизелийн түлш 29 хоногийн нөөцтэй,
- ТС-1 онгоцны түлш 22 хоногийн нөөцтэй байна.

Эх сурвалж: Montsame.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд “Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК хариуцлага хүлээхгүй болно.